



НИЙСЛЭЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН  
ДАРГЫН ТУШААЛ

2014 оны 01 сарын 28 өдөр

Дугаар А/04

Улаанбаатар хот

“Улаанбаатарын өвөл-2014” аялал  
жуулчлалын арга хэмжээ  
зохион байгуулах тухай

Монгол улсын Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.2, Нийслэлийн Засаг даргын 2014 оны А/24 дугаар захирамж, тус газрын дүрмийн 2.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1. Тусгай сонирхлын аялал жуулчлалыг хөгжүүлэх, жуулчны улирлын хугацааг уртасгах зорилгоор “Улаанбаатарын өвөл-2014” арга хэмжээг 2014 оны 02 дугаар сарын 02-ны өдөр Улаанбаатар хотод зохион байгуулахыг Эвент хариуцсан мэргэжилтэн /Б.Оюунзул/-д даалгасугай.

2. “Улаанбаатарын өвөл-2014” аялал жуулчлалын арга хэмжээ зохион байгуулах ажилд шаардагдах зардлын төсвийг хавсралтаар баталсугай.

3. Тэмцээн зохион байгуулахад шаардагдах төсөв 15 158 500 /арван таван сая нэг зуун тавин найман мянга таван зуу/ төгрөгийг холбогдох зардлаас тооцож гаргахыг ахлах нягтлан бодогч /П.Ариунаа/-д зөвшөөрсүгэй.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ  
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Э.БАТТУЛГА

Нийслэлийн Аялал жуулчлалын газрын  
даргын 2014 оны 01 сарын 28 өдрийн  
А/04 тоот тушаалын хавсралт



“УЛААНБААТАРЫН ӨВӨЛ-2014” АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН  
АРГА ХЭМЖЭЭ ЗОХИОН БАЙГУУЛАХ ЗАРДЛЫН ТӨСӨВ

№	Зардлын нэр	Тоо хэмжээ /ширхэг/	Нийт үнэ	Хянасан
1	Анонс хэвлүүлэх	24м <sup>2</sup>	204.000	204.000
2	Фото стикер хэвлүүлэх /1x1.5м2 х 8 ширхэг/	8	180.000	180.000
3	Фото стикер хэвлүүлэх /1.4x2.94м2 х 4 ширхэг/	4	150.000	150.000
4	Самбарт байрлуулах ажлын хөлс	12	132.000	132.000
5	Урилга /англи, Монгол хэлээр/	150	112.000	112.000
6	Эх бэлтгэл /урилга, хөтөлбөр, анонс, мандат/	4	-	-
7	Цом - 6 ширхэг	6	120.000	120.000
8	Шүүгчийн цалин	6	180.000	180.000
9	Телевизийн шторк хийлгэх	15 сек	900.000	900.000
10	Шторк цацах /15 сек/	12	570.000	570.000
11	Урлагийн тоглолт	3	900.000	900.000
12	Хөтлөгч	1	300.000	300.000
13	Өвлийн гэр түрээслэх	2	700.000	700.000
14	Тайзны засал чимэглэл	1	200.000	200.000
15	Гэрийн тохижилт, хүндэт зочдыг хүлээн авах бэлтгэл	2	200.000	200.000
16	Морин /нохой/ чарганы тээвэрлэлтийн зардал	2	260.000	260.000
17	Туслах ажилчдын хөлс	10	250.000	250.000
18	Замын тэмдэг тэмдэглэгээ	15	750.000	750.000
19	Уран гулгалтын болон тэшүүрийн тоглолт үзүүлэх тамирчдын ажлын хөлс	10	350.000	350.000
20	Богино долгионы станц /олон удаа ашиглах/	10	1.100.000	1.100.000
21	Баннер /Олон удаа ашиглах/	2	1.000.000	1.000.000
22	Дисплей /олон удаа ашиглах/	3	1.800.000	1.800.000
23	Шагналын сан	9	3.000.000	3.000.000
24	Хөгжим техник хэрэгсэл, тайз түрээслэх	1	1.800.000	1.800.000
Нийт дүн				15.158.500